



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: Суудлын микроавтобус нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: CR-2012/04

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос Монголбанкны ажлын хэрэгцээнд зориулан суудлын микроавтобус нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн бичиг баримтыг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000.00 (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн турш хүчинтэй байна.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцохгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрнө. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд тушаана.

Тендерийг 2012 оны 12 дугаар 13-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

### **МОНГОЛБАНК**

***Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “А” байр,***

***1 давхар 2 тоот өрөө,***

***Утас: (976) 11-327048, Факс: (976) 11-311471***